



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 74

Баян-Овоо

**Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах, явуулах журам”, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны “2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай” 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэмэлт тодотголд тусгагдсан 5 (тав) нэгж талбарыг малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацааг хавсралтаар баталсугай.

2.Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зарлаж, төслийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 12.00 цаг хүртэл хүлээн авах ажлыг газрын биржийн цахим системээр зохион байгуулахыг Газрыг даамал (Б.Урансайхан)-д даалгасугай.

3.Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХ-ОД

010000184

Сумын Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 28-ны өдрийн
71 дүгээр захирамжийн хавсралт

ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ШИЙДВЭРЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ
ЗОРИУЛАЛТ, ЭЗЭМШҮҮЛЭХ ХУГАЦАА

№	Төлөвлөлтийн нэгж талбар	Эзэмшүүлэх газрын байршил	Газрын хэмжээ [m2]	Газрын зориулалт	Эзэмшүүлэх хугацаа
1	4087637	1-р баг, Онон, Барчийн булан	50000	1624: Мал аж ажуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	15 жил
2	4087636	1-р баг, Онон, Барчийн булан	50000	1624: Мал аж ажуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	15 жил
3	4087635	1-р баг, Онон, Барчийн булан	50000	1624: Мал аж ажуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	15 жил
4	4087634	1-р баг, Онон, Барчийн булан	50000	1624: Мал аж ажуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	15 жил
5	4087699	1-р баг, Онон, Барчийн булан	50000	1624: Мал аж ажуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	15 жил
Нийт			250000		